



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 8/61

Улаанбаатар хот

Г Хууль хэрэгжүүлэх тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох чиг үүрэг нь хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар”-т шилжсэнтэй холбоотой Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл олгохыг Эм, эмнэлгийн хяналт, зохицуулалтын газрын дарга /Б.Цэцэгсайхан/-д даалгасугай.
2. “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар”-т шилжсэн “Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл” олгох комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбулган/-т даалгасугай.



Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
16 сарын 26-ны өдрийн 161  
дугаар тушаалын хавсралт

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын дарга: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга;
- Комиссын дэд дарга: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмийн хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмж, төлөвлөлтийн асуудал хариуцсан дэд дарга;
- Нарийн бичгийн дарга: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн ханган нийлүүлэх, үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Гишүүд: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан дэд дарга;
- Гишүүд: Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга;
- Гишүүд: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга;
- Гишүүд: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын газрын дарга;
- Гишүүд: Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан шинжээч;
- Гишүүд: Нийслэлийн эрүүл мэндийн газрын эмийн сангийн тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Гишүүд: Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах газрын дэд дарга /зөвшилцсөнөөр/;
- Гишүүд: Монголын эмзүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбооны тэргүүн;
- Гишүүд: Авилгатай тэмцэх газрын Олон нийтийн зөвлөлийн гишүүн С.Отгонгэрэл /зөвшилцсөнөөр/;